



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 4/111

Хэрлэн сум

Цалингийн шатлал ахиулах, ур чадварын
нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 332 дугаартай тогтоолоор баталсан 1 дүгээр хавсралт, 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 3, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ын 1.1, 7.1-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2016 онд аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээгээ "Маш сайн", "Сайн" үнэлүүлсэн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Энх-Амгалан, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга С.Мөнхцэцэг нарын цалингийн шатлалыг ахиулан ТЗ-9-5 шатлалаар шинэчлэн тогтоож, Музейн захирал Н.Нямсүрэнд ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тооцож олгосугай.

2. Шинэчлэн тогтоосон цалинг 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг тухайн газрын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 550